

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 24

№ 24/ТУЗ/25

Улаанбаатар хот

“Охин компанид опцион гаргах зөвшөөрөл олгох тухай”

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.1, 62.2.12 дахь заалт, Монложистикс Экүпментс ХХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь заалт, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монложистикс Экүпментс” ХХК-ийн эзэмшлийн “Монложистикс Холдинг” ХК-ийн энгийн хувьцаанд суурилсан опционыг нэгдүгээр хавсралтад заасан нөхцөлөөр гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Гаргасан опционыг “Монложистикс Холдинг” ХК болон түүний охин компаниудад ажиллаж байгаа Зэрэг-5 ба түүнээс дээшхи албан тушаалын түлхүүр ажилтнуудад эзэмшүүлсүгэй.
3. Түлхүүр ажилтнуудын нэрсийн жагсаалт болон ажилтанд эзэмшүүлэх хувьцааны тоог хоёрдугаар хавсралтаар тогтоосугай.
4. Түлхүүр ажилтнуудтай байгуулах “Колл опционы гэрээ”-ний төслийг гуравдугаар хавсралтаар баталсугай.
5. Түлхүүр ажилтнуудтай “Колл опцион”-ы гэрээ байгуулах, түүнтэй холбоотой баримт бичигт гарын үсэг зурах эрхийг “Монложистикс Экүпментс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д олгосугай.
6. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөлд хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



АНЗОРИГТ